

## БУСДЫН ЭРХШЭЭЛД БАЙСАН ҮЕИЙН МОНГОЛЧУУД УЛС ҮНДСЭЭ АВЧ ҮЛДСЭН АРГА УХААНЫ ТҮҮХИЙН АСУУДАЛ

Д.Хүүхэнбаатар

Монгол Улсын Их Сургууль, Нийгмийн Шинжлэх Ухааны Сургууль, Түүхийн тэнхим.

**Өгүүллийн товч утга:** Монголчууд XIII-XIV зууны үед тусгаар хүчирхэг улс болж тогтносон нь дэлхийн түүхэнд онцгой байр суурийг эзлүүлжээ. Бутралын үе гэж хожуу хойно, хайнга томъёолсон үед биеэ даасан гурван монгол тусгаар улсууд байжээ. Манжид дагаж орсон Халхын сонголт нь үндэс угсаатны цаашдын хувь заяаг авч үлдэж чадсан, бас бие даасан холбоотон шинжтэй байж, монголоо хятадад уусах аюулаас аварч чадсан байна. 1921-1990-ээд он бол ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн орнуудын хараат нөлөөний байсныг нотлон гаргахыг чармайсан. Үүнийг эсэргүүцсэн тэмцлийн манлайд А.Амар, Д.Төмөр-Очир нар байсан гэсэн дүгнэлт хийлээ. ЗХУ-д нэгдэх урвагч гутранч муу үзлийг шүүмжлэлтэй авч үзэв. 1945 оны Крымын бага хурлаар дэлхийн 3 том гүрнээр зөвшөөрүүлсэн нь дипломатын дэлхийн том ялалт байлаа. Тусгаар тогтнолын асуудлаар санал асуулга явуулж, 1946 онд ЗХУ-тай гэрээ байгуулж, социализмын гэгдэх орнуудтай бүгдтэй нь дипломат харилцаа тогтоож гадаад системийн бус гэгдэх орнуудтай тал бүрээр харилцаж эхэлсэн нь тэр үеийн нам төр засаг зүгээр нэг хүлцэнгүй даган байгаагүй уран арга ухаанаар тэмцэж хэрэгжүүлж чадсан байна.

**Түлхүүр үг:** Тусгаар тогтнол, эв нэгдэл, эрхшээлд бие даах, улс үндсээ авч үлдэх арга ухаан.

Монголын түүхээ эргэн эргэн үзэхүл яндаж барагдашгүй ихийн зэрэгцээ ертөнцөд өөр хаана ч давтагдаагүй гайхамшигт түүхэн хөгжлийн бие даасан цогцолбор, иймээс нүүдэлчдийн түүхийг үзэх судлахад их өөрчлөлт хийхийг шаардаж байна. 1950-иад оноос 90-ээд он хүртэл монголын түүхийг хүний заавраар, хүний номоор бичсээр нэг үзэл сурталд баригдсаар иржээ. 1990-ээд оноос хойш түүхээ монгол хүний ухаанаар судлах сайхан боломж нээгдэхийн хамт түүх соёлыг хэтрүүлэн үнэлэх, хий хоосон хөөрөгдөх, ор тас үгүйсгэх, улс төржүүлэх боллоо. Бодит байдал өнөөдөр дан ганц Өрнөдийн арга барилаар үнэнийг чадахгүй нь тов тодорхой боллоо. Монголын ард түмэн өөрийнхөө түүхийг илүү өвөрмөц, илүү өргөн судалгааны арга барилаар өвөрмөцөөр туурвин бүтээхийг хүсэж байна.

Хоёр их улсын дунд өчүүхэн монгол уусан усталгүй явсаар XXI зуунтай золгосны чухамхүү учир шалтгааныг өнөөдөр бүрэн утгаар нь шинжлэх ухааны үндсэн дээр тайлбарлаж чадаагүй байна.

Манжийн ноёрхолын 220 жилийн тэмцлийн түүхийг үзэхэд Монгол гэдэг их үндэстэн уусах аюулд автаж, манж өөрөө уусаж шингээд Өвөрмонголчууд Хятад иргэн улсад, Буриадууд Орост уусан автан шингэсэн байна. Монголчууд бүрмөсөн уусан автах уу, эсвэл хувь заяаны эрхээр харийн эрхшээлд байвч улс үндэстнээ аварч гарах уу гэсэн ацан зорилт тулгарсан юм. Чухам энэ үед Халхчууд товойн тодорч өөрийн уламжлалт газар нутаг дээрээ лавтай оршин тогтнож, түүний гүйцэтгэх бүх үйл ажиллагаа гол үүрэгтэй нөлөө бүхий ач холбогдолтой болжээ. Энэ бол Халх төвт Монгол улсаа тогтоох хөдөлгөөн өрнөж, Халх төвийн үзэл санаа бүрэлджээ. Халх түмний магтаалд:

"Хангайн ард нутаглан сууж

Харийн дайсанд халх болсон

Халуун аминд түшээ болсон

Халх түмэн чину тэр бүхийгээр ажаамуу"<sup>1</sup> хэмээн дуурсган алдаршуулжээ.

Зарим эрдэмтэд халх түмэн нь "одоогийн БНМАУ /өнөөгийн монгол улсын/ төв

<sup>1</sup> Шара тужа. 1996. Чингис хааны их өчиг. Ц.Дамдинсүрэн. Зуун билэг. 82-83 т

нутгийг эзэмшиж, Хархорумын орчим төвлөрч байжээ<sup>2</sup> гэж үзсэн нь нэн чухал дүгнэлт мөн.

Бусдын эрхшээлд байсан үеийг он цагаар хувааж үзвэл:

Нэгд. 1691-1911. Манжийн эрхшээлийн үе”

Хоёрт. 1921-1990 он /Зөвлөлт/ Оросын дагуул орон байсан үе гэж тоймлож болмоор.

Юань улсыг унасны дараа монгол газар тогтсон бутралын эх үеийн гурван Монгол нь тусгаар улсууд байж, гадагшаа бие даан харилцаж байсан XIII зууны II хагасын XVII-XVIII зууны I хагас хүртэл улируулан авч үзэх нь зөв юм.

Энэхүү бяцхан өгүүлэлд ийм зорилт тавиагүй ч монголын тусгаар тогтнолын тэмцлийн агуу их өвийг дараах үедээ үлдээжээ хэмээн бүрэн утгаар нь онцлон тэмдэглэж байна.<sup>3</sup>

Монголын түүхэнд XX зууны эхэн үеийн Манжаас хагацсан 10 жилийн үйл явц эгзэгтэй. Үүнийг :

1. 1911-1915 онд тусгаар тогтносон Монгол улс.

2. 1915-1919 онд Автономит Монгол улс.

3. 1919-1921 оны II сар. Хятадын цэргийн хүчээр тогтсон Дундат Улсын муж.

4. 1921 оны III-ҮII сар. Бароны дэмжилгээр сэргээсэн автономит улс хийгээд Хиагт дахь ардын Түр Засгийн Газар хэмээх 2 засагт улс гэж болмоор санагдана. Зөвхөн үүнээс үзэхэд 10-хан жилд монголчууд гадна дотны ямар олон гамшиг зовлон амссаныг харж болно. Энэ үеийг бид орхиж өнгөрөх, тойрч гарах, бүрхэгдүүлэх ямарч эрх үгүй билээ.

Харийн хүчнийг ашиглаж тусгаар байдлаа тогтоох бодлого ч боловсорч төлөвшжээ. Монголын эгзэгтэй түүхэн эргэлтийн үед хэнийг түшиглэх вэ? гэдэг асуудал заавал тавигддаг байна. 1691 онд Халхчууд Хятадыг биш, Манжийг түшихээр дагаж орсон нь зайлшгүй бөгөөд зөв сонголт байсныг түүхийн хойчийн бодит хэрэг явдал нотолж өгсөн.

Манжид үнэнчийн дүрээр хүчин зүтгэж<sup>4</sup> XX зуун гарахад Монголчууд хилтэйгээ, хэлтэйгээ үлдэж чадаад соёл урлаг тасарч зогсоогүй, шашин дэлгэрч, хот суурин баригдаж, уламжлалт ёс заншлаа аван ирсэн байна. Түүнийг түүхнээ "язгуурын ёсыг сахих" гэдгээр томъёолж иржээ. Түүхэн баримтуудаас үзэхэд Монголын эх оронч дэвшилт үндэсний үзэлтний бодлого нь үндэс угсаагаа сахих үйл ажиллагаа болж байсан юм.

Энэ үеийн монголчуудын манжтай харьцсан харьцаа нь монголыг хятадад уусгахгүй өөртөө засах дотоод бүрэн эрхт байдлаа хадгалж хамгаалахад оршиж байжээ<sup>5</sup>. Энэ бүхэнд Манжийн төрийн бодлогыг овсгоотой ухаалаг ашиглаж өөрийгээ аварсанд байгаа юм. Манжийн монголын талаар баримталж байсан бодлогыг эрдэмтэн Ж.Болдбаатар дүгнэхдээ "...өрөнхийдээ Монголыг түшмэг холбоотны байдалтай байсан. ...Бээжин дэх ноёрхол унавал Монгол руу шилжин, улсаа нүүдэлчдийн гүрний хэмжээнд барьж байх бодлого явуулж байсантай холбоотой"<sup>6</sup> гэсэн сонирхолтой шинэлэг санааг дэвшүүлжээ.

Эл өгүүллийг бичигч чухамхүү энэ үеийн монголын хаад, ноёдоос сэргүүлэн явуулсан бодлогыг уялдуулж үзэхийг оролдсон билээ. Манжид Монгол дагаж орсон 1691 оноос тоолвол 220 жил зөвхөн Халхад ногдох бөгөөд бусад Монголын хувьд өөр өөр цаг хугацаа гардаг. Бутралын гэж хожуу томъёолсон үе бол Тогоонтөмөрөөс хойш 22 хаан суусан бөгөөд "Эсэн хаан /1570-1634/,

<sup>2</sup> Д Гонгор. Халх товчоон. УБ. 1978. 261 т

<sup>3</sup> Монгол улсын түүх.

<sup>4</sup> Б.Буянчуулган, Манжаас Монголыг эзэрхсэн үеийг илэрхийлсэн хэрэглүүн.УБ. 1934.

Ш.Нацагдорж, Манжийн эрхшээлд байсан үеийн Халхын хураангуй түүх. /1891-1911/ УБ. 1963.

<sup>5</sup> Ш.Нацагдорж "Монголын феодализмын үндсэн замнал" УБ. 1978.

<sup>6</sup> Монгол улсын түүх. УБ. 1999. 63-р тал

Батмөнх Даян хаан /1466-1504/, Түмэн засагт хааны /1558-1593/ үед бүх түмнийг товчлон захирч, Монголын төр хэмжээгүй эрхт хаант засгийн хэлбэрээ бүрнээ хадгалж байсан гэж үзэж болох юм<sup>7</sup> гэж үзсэн нь чухал дүгнэлт мөн. Тийм ч учраас "XVII зууны 20-иод оноос XVIII зууны II хагас хүртэл Манж Чин улс ... Монголыг түшмэг холбооны байдалтай байлгах бодлого явуулж байсан билээ<sup>8</sup> гэсэн дүгнэлтийг зөв гэж үзэж байна. Манжийн хааны зарлигаар Монгол аймаг, хошуудыг олшруулсан хэдий ч түүнийг захирах эрх мэдлийг дан монголчууд мэдэн барьж чадсан бөгөөд нэг ч манж, хятад ноён, аймаг, хошуу захирч байгаагүй билээ. Өөр нэг сонин баримт бол Халхын ноён Андахай мянган өрх дагуулж Орост ойж орсон бөгөөд 1717 онд Орос, Манжийн хилийн хэлэлцээр батлагдахад түүний хүү Амар хэлмэрчээр оролцсон байдаг. 1727 оны хэлэлцээрээр монголчууд 2 их улсаар өөрийнхөө хилийг тогтоолгож, монгол хойт хилээ өөрсдөө батлан сахисан нь бас л улс үндсээ газар нутгаа аварч үлдэхийн нэгэн баталгаа болж өгөв. Халхын ноёд улам өргөн эрхтэй бие даасан бодлого явуулсан нь манж хаан аргагүйдэж гадаад улс оронтой гэрээ хэлэлцээр хийхийг нь 1721 онд хориглоход хүргэсэн юм.

1709-1796 онуудад болсон монголын ноёдын удаа дараагийн чуулганаар дотоод бодлогоо тодорхойлон "Халх журам" хэмээх алдарт хуулийг баталж гаргаад манжийн бүхий л үед хэрэгжсээр мөрдөгдсөөр байсан нь<sup>9</sup> улс үндсээ аврах бас нэг гайхамшиг болжээ. Богдод даншиг өргөх шашны ёслол, ноёдын чуулган нь улам бүр улс төрийн агуулгатай болж 1911 оныг хүрч ирсэн нь бие даасан бодлогын нотолгоо гэж хэлж болно. Энэ их үйлст шашин түүний нөлөө бүхий хутагт хувилгаад оролцох идэвх нь ихэсч, сүм хийд хурал номоо тусгайлан зориулан хурж мэргэн лам нар аль улсыг түших тухайд зааж зурах болжээ. Даншигийн наадам, 10 засгийн наадам, 7 хошуу наадам зэрэг төрийн чанартай ёслол хүндэтгэл олширсон нь цаанаа гүн учиртай.

Манжийн төрийн хүнд хүчир алба гэгддэг "9 цагааны бэлэг"-ийг бүр 1634 оноос өөрсдийн санаачилгаар халхын ноёд бэлгийн журмаар өргөж эхэлсэн бөгөөд энэ бол аль болох хөндий байх, "Манж хаантай харилцах дипломат бодлого, арга байсан"<sup>10</sup> ажээ.

Монголчууд хэл, хэл бичгээ нандигнан эрхэмлэж, дотоодын бүх хэргийг хуучин бичгээрээ хөтөлж, сургах сургуулийн асуудал ч хөндөгдөж ирсэн байна.

Уламжлалт бөө мөргөлийн тэнгэрээ шүтэх, уул усаа тахих, дархлан цаазлах ёс хүчтэй болж ирсэн нь ч бас л цаанаа монголоо хамгаалах нарийн ухаан байлаа. Байгалийг шүтэж амьдрах, бэлчээрийг хамгаалах, тариа тариулахгүй, газар хагалахыг эсэргүүцэж ирсэн нь үүнтэй холбогдож шинэ агуулгатай болжээ. Манж хаан Монголд аймгийн жанжны тушаал байгуулан, хошуу цэрэг бий болгохыг зөвшөөрсөнийг монголчууд өөрийн гэсэн цэргийн зохион байгуулалтай, цэргийн хүчтэй боллоо гэж үзэж байсан байна. Аймгийн жанжны тушаал, эрх мэдлийг ажиглахад энэ нь мэдэгддэг юм.

Манжийн эрхшээлд байсан үеийн явцад Монголчууд Их улсыг шүтэж харилцан туслалцах, бага улсын ёсоор орших, өөрийгөө уусгаж, устгалгүй авч үлдэх Монгол ухаан, бодлогыг олон улсын харилцааны түүхэнд цоо шинээр оруулж Монголоороо үлдэж, аж төрөх ёсыг түүхэн практикт хэрэгжүүлсэн онцлогтой гэсэн дүгнэлтийг хийх бололцоог өгч байна.

Тухайн үе бүхэн улс үндэсний төлөө тэмцэгч, зүтгэлтнүүдийг төрүүлж байлаа. Манжийн эрхшээлийн эхэн үед Занабазар гэгээн, Чихүндорж түшээт хаан, Амарсанаа, Чингүнжав, Галдан бошигт нар тодорсон билээ. XX зууны эх болоход 1911 оны үндэсний хувьсгалчид Ханддорж Чинван, Сайн ноён хаан

<sup>7</sup> Мөн ном. 68-р тал

<sup>8</sup> Мөн ном. 69-р тал

<sup>9</sup> С.Жаланаажав. Халх журам бол Монголын хууль цаазны дурсгалт бичиг мөн. УБ. 1958

<sup>10</sup> История Монгольской Народной Республики. Москва. 1934. 160-р тал



Намнансүрэн, VIII Богд Жавзандамба хутагт, Да лам Цэрэнчимэд, гүн Хайсан болон тэдний хамтран зүтгэгчид шалгарч товойсон. 1921 оны Үндэсний ардчилсан хувьсгалын зүтгэлтнүүд Бодоо, Данзан, Сүхбаатар, Чойбалсан, Лосол, Догсом, Чагдаржав, талархан дэмжигч Богд лам, Да лам Пунцагдорж, Жалханз хутагт Дамдинбазар, Дилов хутагт Жамсранжав, ван Ширнэндамдин, Амар, Цэрэндорж, Дамбадорж, Цэвээн, Дэндэв, Ю.Цэдэнбал, П.Гэндэн нарын зүтгэлтнүүдийг төрүүлжээ.

XX зуунд үндэс угсаагаа аврах улмаар улсынхаа тусгаар тогтнолыг байлдан олох тэмцлийн үе шатыг 2 хэсэгт:

I-рт. XX зууны эхнээс 1921 оныг хүртэл Цагаан хаант Орос улсыг, 1921 оноос 1990-ээд он хүртэл Улаан Орос улс /ЗСБНХУ/-ыг түшиглэсэн түүний хараат "ивгээлийн орон" болон явж иржээ.

1911-1913 оны үндэсний эрх чөлөөний тэмцлийн гол зорилтыг VIII Богд, дөрвөн аймгийн хаад, Цагаан хаанд илгээсэн бичигтээ: "Их улсад шүтэж, бага улсын ёсоор харилцан туслалцах<sup>11</sup> гэж томъёолон тодорхойлсон нь язгуурын ёсыг сахих бодлогоос урагш ахижээ. Хаант Орос монголчуудын энэ бодлогод маш болгоомжтой хандаж, өөрийгөө бүрэн ашигтайгаар, олон улсын дунд гэм зэмгүйгээр өөрийн болгох, нөлөөний орноо гартаа байлгах чигийг тууштай барьжээ. Хаант Орост 1912 оны Ханддорж Чинвангийн, 1913 онд сайн ноён хан Намнансүрэн нарын айлчлалт, 1912 оны хүрээний Монгол оросын хэлэлцээрээс хаант Орос үнэхээр "ивгээн тэтгэгч, түшиг улс" болжээ. 1912 онд Эрхүүгийн генерал-губернатор Ханддорж нарт хэлэхдээ: "Бидний хоёр улс өдгөө зузаан найрамдсаны дээр манай Эрхүү хотын харъяат олон мужууд цөм танай Монгол улс зах нийлж худалдаа нэвтрэх тул бид нарын найрамдал нэн ч зузаан"<sup>12</sup> хэмээжээ.

Цагаан хаан монголчуудыг мөн оны өвлийн дунд сарын арван долооноо хүлээн аваад эзэн мэтээр "Танай гадаад Монголыг хэрхэвч бээр туслан өмгөөлмүй. Хэрэв хэрэг учир буй аваас хэлсээр байтугай, ...Найрамдлын уран аргаар хятадтай хэлэлцүүлсүгэй"<sup>13</sup> хэмээн тал засан илэрхийлжээ. Дээрх баримтуудаас үзэхэд үнэхээр Хаант Орос Лениний хэлснээр монголыг "энхрийлэн тэвэрчээ". Ахархан хугацаатай ч түүхэн үйл явц, үр дүн, шинэ хойчоо бэлдэн онцгой ач холбогдолтой сургамж, туршлагыг үлдээсэн болохоор эрдэмтдийн анхаарлыг татсаар судлагдсаар иржээ. Ташрамд хэлэхэд монгол улс тусгаар тогтнолоо нотлон улс үндэснийхээ түүхийг энэхэн хугацаанд "Зарлигаар тогтоосон Монгол улсын шаштир" /11 дэвтэр. УННС. гар бичмэл/ хэмээх нэрээр бүтээжээ.

1921-1990-ээд он хүрч иртэл судалгааны нэлээд чамбай бүтээлүүд гарч нийтийн хүртээл болжээ. "БНМАУ-ын түүх, нэгэн боть. III хэвлэл. УБ. 1984", "БНМАУ-ын түүх. I-III б. УБ. 1966-1969" хэмээх нэн эртээс эдүгээ үеэ хүртэл багтаасан суурь судалгааны том бүтээлүүд нь шинжлэх ухааны арга зүйн үндсэн дээр бичигдсэн нь, монголын түүхийн үеүд, гол гол асуудлуудад хариу өгсөн нуруутай шаштир болжээ.

Дээрх бүтээлүүд манжаас монголчууд ангижирсан 10-аад жилийн түүхийг ч чандлан үзсэн байдагт энд гоцлон оруулж байгаа юм. Судлаачдаас Л.Дэндэв<sup>14</sup>, Ц.Пунцагноров<sup>15</sup>, Л.Жамсран<sup>16</sup>, Ж.Урангуа<sup>17</sup>, Л.Бат-Очир, С.Отгонжаргал<sup>18</sup>,

<sup>11</sup> "Үнэн". Цагаан хаанд бараалхсан тухай тэмдэглэл" 1991. X. №134 /17988/.

<sup>12</sup> Мөн сонин

<sup>13</sup> Үнэн. 1991. № 127 /17975/

<sup>14</sup> Л.Дэндэв. Монголын товч түүх. УБ. 1934

<sup>15</sup> Ц.Пунцагноров. Монголын автономитийн үеийн түүх. УБ. 1955

<sup>16</sup> Л.Жамсран. Монголчуудын сэргэн мандалтын эхэн. /1911-1913/. УБ. 1992

<sup>17</sup> Ж.Урангуа. "XX зууны эхэн үеийн Ар монгол дахь шинэтгэл" УБ

<sup>18</sup> Л.Бат-Очир, С.Отгонжаргал. "XX зууны монгол дахь улс төрийн түүхэн үйл явц" УБ. 1996

И.М.Майский<sup>19</sup> нарын зэрэг олон түүхчдийн бүтээл гарчээ. Монголын шинэ түүхийн 2 дахь үе гарахад дэлхий дахинд ба монголд онцлог эргэлтийн чанартай үйл явдлуудаар элбэг байлаа. 1917 онд Орос оронд их хувьсгал гарч, ЗОУ тогтож гадаадын интервенц, иргэний дайны сүйрлийн аюулд нэрвэгдэж байсан ч Ленин тэргүүтэй Оросын удирдагчид Монголын хэрэгт Москва, Бээжин гар дүрэх ёсгүй, Монгол бол биеэ даасан тусгаар тогтносон улс, мөн гэдгийг зөвшөөрч байгаагаа бүр 1918, 1919 онуудад гаргасан уриа, нотондоо дэлхийн олон улсын өмнө бүрэн хариуцлагатай мэдэгдсэн билээ.

Монголчуудад үндэс угсаагаа хадгалан хамгаалж эн тэргүүнд тусгаар тогтнолоо байлдан олох гадаад таатай нөхцөл цагийн эрхээр тохиожээ. Европ газар хувьсгалын давалгаа цалгиж, дорно зүгт үндэсний эрх чөлөөний хувьсгал дэлгэрэн өрнөв.

Монгол оронд үндэсний тусгаар тогтнолоо байлдан олох их тэмцлийг удирдах улс төрийн нам-МАН байгуулагдаж, 1921 оны III-VII сард Монголын үндэсний ардчилсан хувьсгал яллаа. Монголчууд Их Зөвлөлт Орос улсыг шүтэн харилцан туслалцан, бага улсын ёсоор аж төрж, бүрэн тусгаар тогтнолоо бататган хэрэгжүүлэх, улс үндсээ аврах зам нээгдлээ гэж үзсэн билээ.

Хувьсгал ялсаны дараахан 1921 оны VII сарын 19-нд дэлхийн улс оронд тусгаар тогтнолоо зарлан тунхагласан нь улс үндсээ нийтээр зөвшөөрүүлэх зоригтой шийдмэг алхам байлаа. Дараачийн том алхам бол 1921 оны 10 сарын 5-нд Монгол-Зөвлөлтийн найрамдлын гэрээнд Москва хотноо гарын үсэг зурсан явдал юм. Энэ нь монголын талаас дэлхийн их гүрний нэг Оросоор тусгаар тогтнолоо зөвшөөрүүлж чадсан том амжилт байлаа.

Богдтой байгуулсан "тангарагийн гэрээний үндсэн дээр төр улсаа хэмжээт эрхт хаант Монгол улс"<sup>20</sup> болсноо зарлан тунхаглаж, улс үндсээ тусгаар тогтнолын уламжлалаа сахин баталгаажуулсан хэрэг байлаа. Үндэсний ардчилсан хувьсгалын цаашдын хувь заяа нь төр засгаа хэрхэн сонгож авах төр засаглалын хэлбэр тогтолцоо, уламжлалаа бүтээлчээр өвлөх болоод улс үндсээ аврах гол хэрэглүүрийн нэг болгож чадсан юм. Энэ талаар сүүлийн үед онцлон анхаарч судалгааны шинэлэг сайн бүтээлүүд гарлаа. Тийм судлаачид М.Санждорж<sup>21</sup>, С.Жалан-Аажав<sup>22</sup>, И.Дашням<sup>23</sup>, Ж.Болдбаатар, Д.Лүндэанжанцан<sup>24</sup>, Б.Содовсүрэн<sup>25</sup>, С.Нарангэрэл<sup>26</sup>, С.Отгонжаргал<sup>27</sup> нарын бүтээл туурвилууд орох бөгөөд хамтын хэд хэдэн томоохон бүтээлүүд гарчээ<sup>28</sup>. Бүгд найрамдах засгийн хэрэг гэгч ч улсын тусгаар тогтнолын ирээдүйтэй холбоотой.

1924 онд Улсын анхдугаар их хурлаа хийж, Үндсэн хуулиа батлан гаргалаа. Үндсэн хуулинд "Харъяат улсад Бүгд найрамдах ардын засгийг явуулж, да жунтан гэдэг ерөнхий даргыг сонгохгүй, улсын бүх дээд эрхийг Улсын Их Хуралд ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраа шилжүүлэн залж

<sup>19</sup> И.М.Майский. Монголия накануне революций. М 1959

<sup>20</sup> Монгол улсын түүх. УБ. 1999. 71-72 тал. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. УБ. 2001. 9-11 тал.

<sup>21</sup> М.Санждорж. Ардын төрийн түүх. УБ. 1974.

<sup>22</sup> С.Жаланаажав. Ардын хувьсгалт төрийн хууль тогтоох үйл ажиллагааны үндсэн чиглэл. УБ. 1967

<sup>23</sup> И.Дашням. БНМАУ-ын сонгуулийн систем. УБ. 1975

<sup>24</sup> Ж.Болдбаатар, Д.Лүндэанжанцан. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, УБ. 1997

<sup>25</sup> Б.Содовсүрэн. Хувьсгалын өмнөх Монголын төр ба хууль цааз. /1911-1920/ УБ. 1977

<sup>26</sup> С.Нарангэрэл. Монголын ба дэлхийн эрх зүйн тогтолцоо. УБ. 2001

<sup>27</sup> С.Отгонжаргал. XX зууны Монголын түүхийг шинээр эргэн харахуй. /1921-1990/. УБ. 2003

<sup>28</sup> Монголын төрийн байгуулал, улс төрийн сэтгэлгээний хөгжилт /МЭӨ III-МЭ XX зуун/ 1-2 б. УБ. 1995. 1997. Монгол улсын төр, эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. УБ. 2001



хадгалахаар<sup>29</sup> тогтоож, үндсэн хуульт парламентын БНУ болсон нь хувьсгалаас хойш улс үндсээ бэхжүүлэхэд олсон том ялалт болжээ.

Хорь, гучаад оныг ажиглахад монголын нам, төр засгийн удирдлагад жинхэнэ үндэсний ардчилсан чиглэлээ барьж үндэсний онцлогоо дээдлэх бодлоготой "баруунтан" гэгдэж зохиомлоор буруутгагдаж, хожим хэлмэгдлийн хар шуурганд эрсдсэн үндэсний үзэлтнүүд, ЗОУ-ыг үг дуугүй залбиран дагагчид, зориуд бэлдсэн залуу хүчин хэт "зүүний" үзэл бодлоор өвчилсөн, улс үндэсний эрх ашгийг огоорон, устгах, сөнөөхийг ажлын аргаа болгосон "зүүнтэн" хоёр сөрөг талууд байсан байна.

1931 оны засаг захиргааны өөрчлөлт нь бие даасан улсын тусгаар тогтнон орших, төр засгийг хязгаар нутаг олон түмэнд ойртуулах хэрэгт ач холбогдолтой болсон гэж үзэж болно. Үүний хамт эерэг, сөрөг талтай, нутгийн ард олны ашиг сонирхолд харшилсан, бэлчээр нутаг, усны талаар сөрөг талтай гэдгийг эрдэмтэд бичиж байгаа нь оргүй биш.

Монголд социализм байгуулах гэсэн балмад туршилтыг засаж залруулсан "шинэ эргэлтийн бодлого" бол Коминтерн, ЗХУ-ын сталинч удирдлага, тэдний дуулгавартай гар хөл болсон монголын "зүүнтэнд" цохилт өгсөн улс үндсээ аварч үлдэх гэсэн үндэсний үзэлтний ялалт гэж үзэх ёстой. Гэхдээ 1921 оны Монгол-Зөвлөлтийн гэрээнд бүрэн тэгш байж чадаагүй бөгөөд "Монгол ардын намын удирдлага тэр үедээ сэтгэл хангалуун байгаагүй нь Сталины заалтаар үндэстнүүдийг "хүчээр нэгтгэх" бодлоготой холбоотой байсан бололтой"<sup>30</sup>.

Гэрээнд тусгах ёстой монголын талын төслийг гэрээнээс хассан нь Монголын тусгаар тогтнолыг далдуураа хүлээн зөвшөөрөхгүйн баталгаа болж өгдөг. Оростой Монголын хилийг тогтоох асуудалтай уялдуулж, тагна Урианхайг хятадын нутаг гэж үзсэн төдийгүй монголтой хил тогтоох асуудлыг хятадтай хил тогтоох асуудалтай холбон үзэж хойшлуулсан болон аливаа концессийг Монгол дангаар шийдэж байх асуудлыг хориглосон зэрэг нь сонин юм гэсэн судлаачийн дүгнэлтийг анзааралгүй өнгөрч болохгүй.

Энэ нь үнэн болохыг 1924 оны V сарын 31-нд байгуулагдсан ЗОУ-Хятадын хэлэлцээ бэлээхэн нотолж, Орос Монголыг хятадын нутаг дэвсгэрийн салшгүй хэсэг мөн гэж зөвшөөрчээ. Бас сталинч улс төрчид монголын нам, төрийн удирдагчдыг хооронд нь хутган үймүүлэх ажиллагаа явуулж, улмаар хагалан бутаргах аргад шилжсэн тухай судлаач Лха.Дарьсүрэн баримтаар нотолсон зоримог, шинэлэг санаатай санал нийлж байна.

1921-1928 онд Монголын тууштай үндэсний үзэлтэн зүтгэлтнүүд Коминтерн, ЗХУК/Б/Н, Зөвлөлтийнхний эсрэг улс үндэснийхээ бүрэн эрхтэй бие даасан байдлын төлөө зоригтой тэмцсэн юм<sup>31</sup>.

Д.Бодоо "Зөвлөлт Орос Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн гэдэг худлаа" гэж зоригтой хэлж, өөр хоорондоо сөргөлдөж, улмаар түүнийг ардын засгийг устгахыг зөвлөсөн гэсэн хэмээн эсэргүү хэрэг үүссэн, гэм зэмгүй арван таван хүнийг цаазаар аваачсан улс төрийн бурангуй хилсдүүлэлт бүр 1922 оноос эхэлсэн нь тодорхой. Улс үндэстнээ авч үлдэх ухаантан тэмцэгчдийг ийм хувь заяа хүлээж байсан юм. Капиталист биш хөгжлийн зам гэгчийг үл зөвшөөрсөн С.Данзан хилэнцэт ялт хэргийн золиос болсон. Коминтерны шууд тулгасан "зөвлөлгөө"-г тухай бүр няцааж, 1928 оны эхээр Ц.Дамбадорж түүний илтгэлд гаргахаар төлөвлөсөн тогтоолыг хүлээж аваагүй байна. Үүнийг улс үндэсний хойчийн хувь заяатай холбон үзэж байлаа. Тэрээр "монголын дотор үл

<sup>29</sup> БНМАУ-ын их бага хурлын тогтоол. Үндсэн хууль. Тунхгууд. УБ. 1956. 29 тал

<sup>30</sup> Үнэн. 1994. XI.4. № 75 /18350/

<sup>31</sup> Монголын түүхийн хураангуй хэрэглүүн. V-VI дэвтэр. УБ. 1995. Мөн ном. VII-VIII дэвтэр. УБ 2000. Л.Бат-Очир, С.Отгонжаргал. XX зууны монгол дахь улс төрийн түүхэн үйл явц. УБ 1996. 49-76 тал

чадах зүйл хаяа цөмийг шууд зөвшөөрөхөд бэрхтэй" гэж няцаажээ. Бас н. Петровын хувийн захидал зөвлөлгөөг ч зөвшөөрөөгүй байна. Энэ нь Коминтерн холбоогоо түр түдгэлзэх төлөөлөгчөө буцаан татах санал гарахад хүргэжээ. Коминтерн, Оросын сталинч бурангуй дэглэмийг монголд тогтоохыг эсэргүүцсэн том дэлбэрэлт бол лам, хар, малчин ард, нам эвлэлийн гишүүд ч оролцсон. 1932 онд баруун 4 аймагт түрхрэн гарсан бослого бөгөөд бүр 1930-аад онуудад Өмнөд хил хязгаарын 10 гаруй аймагт гарсан дүрвэх хөдөлгөөн нь үүний нэг тод баримт юм. Эх монголд нь тогтож буй дэглэмд ард олон үл тэсвэрлэн төрөлх, нутгаа орхиж үхэж мөхөхгүйн эрхээр элэг нэгтнээ эгээрэн, харийн хилийг давахад хүрсэн байна. Коминтерн, МАХН, улсын дотоод хэрэгт түрэмгийлэн оролцож зааж, заавардаж, тулгаж байсан ч түүнийг хүлээж аваагүй бүр эхнээсээ улс үндэснийхээ бие даасан тусгаар байдлыг тогтоон бэхжүүлэх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсээр байлаа. Үүний тодорхой жишээ нь бүр 1923 онд "Эдийн засгийн үндсэн бодлого" баримтыг батлан мөрдсөн нь улс орноо хэрхэн хөгжүүлэх, үндэсний эрх ашгаа бүрэн илэрхийлж хамгаалсан үндэсний программ байлаа. Энэ хөтөлбөр хэрхэн хэрэгжиж, ямар саад, бэрхшээлтэй тулгарч байсныг тун бага судалжээ.

Тэр үеийн төр, засаг, намын их хурлуудын шийдвэрүүд нь энэхүү хөтөлбөрийг баримталсан түүнд тулгуурласан байдаг юм. 1924 онд худалдаа аж үйлдвэрийн банк байгуулж, мөнгөн тэмдэгт гаргаж, үндэсний санхүүгийн шинэ тогтолцоог бүрэлдүүлэв.

Улс ба эд хэрэглэгчдийн хоршооллыг дэмжин түргэн явцтай хөгжүүлэхэд гоц анхаарч, дотоодын зах зээлийг шинээр тогтоов. Бас аж үйлдвэрийн өөрийн гэсэн салбаруудыг шинээр суурийг нь тавьж эхэлсэн нь монгол орны эдийн засгийн тусгаар тогтнолыг цогцлон бүтээх гэсэн их үйлсийн эхлэл байлаа.<sup>32</sup> Харин түүний явц, үр дүн нь хүссэнээр болоогүй билээ.

Монгол улсыг ЗСБНХУ, Хятад зэрэг бусад улсаас зөвшөөрөн хүлээсэн Швейцар мэт төвийг сахисан улс байх ёстой гэж тодорхойлжээ. Монгол үндэстнийг өөртөө нэгтгэх, нэгдсэн Монгол улс болох асуудал ч тодорхой тавигджээ. Буриад, торгууд, дотоод монгол, баргын зэрэг нүүдэллэн ирэгсдийг хөхүүлэн дэмжиж байлаа. Монгол үндэстнээ нэгтгэх үзэл, бодлогыг тууштай баримтлагч, нэрт зүтгэлтэн нь С.Данзан байжээ. Улс орноо батлан хамгаалах талаар авсан дорвитой арга хэмжээнүүд нь оршин тогтнох найдвартай хүчийг цогцлон бүрэлдүүлсэнээр шийдвэрлэх ач холбогдолтой болов.

Олон улсын талбарт мэдэгдэхүйц нөлөөтэй болсон 1936 оны III сарын 12-ны Монгол-Зөвлөлтийн хооронд 1934 оны аман хэлэлцээрийн үндсэн дээр харилцан туслалцах гэрээнд гарын үсэг зурсанаар Монгол улсаа бат найдвартай өмгөөлөн хамгаалах гадаад дахь цэргийн хүчирхэг хүчинтэй болсоноо баталгаажуулж чаджээ. Элчин сайд Түшээ гүн Даваагийн эсэргүүцлийн нотны хариу болгож, ЗХУ, Хятадын /1925/ гэрээ нь ЗХУ, БНМАУ-ын 1921 оны гэрээнд огт харшлахгүй гэдгийг дэлхий дахины өмнө хэлүүлж, "Хэрэв Японы зүгээс БНМАУ-д довтолж, түүний тусгаар тогтнолд халдах юм бол ЗХУ, БНМАУ-д 1921 онд тусалсантайгаа адил тусална"<sup>33</sup> гэсэн ам андгайгийг нь авахуулж чадсан нь дипломатын том амжилт байлаа. Үүний хамт хоёр улсын аль нэгэнд гурав дахь этгээд довтолвол харилцан цэрэг зэвсгийн тусламж үзүүлэх үүргийг хүлээсэн билээ.

Халх голд Японы түрэмгийлэгчдийг ЗХУ-ын цэргийн хүчинтэй хамтран бут цохиж ялсан нь тусгаар тогтнол, улс үндсээ цэрэг зэвсгийн хүчээр хамгаалсан тод жишээ болов. Эх орны их дайны үед зөвлөлтийн ард түмэн улаан армид чадах бүхнээрээ тусалж дорно зүгт Японы аюулаас өргөн зурвас газраар

<sup>32</sup> С.Отгонжаргал. ХХ зууны монголын түүхийг шинээр эргэн харахуй. /1921-1990/ УБ. 2003. 43-50 тал

<sup>33</sup> Дипломатический словарь. М.т.III. 252 тал



хаацайлж хамгаалж байсан нь монголчууд бусдын хувь заяаны төлөө санаа тавьдаг энэрэнгүй үндэстэн, болохоо харууллаа.

Манай улс 1945 онд Японы эсрэг дайнд цэрэг зэвсгийн хүчээр оролцсон бөгөөд түүнээ чөлөөлөх дайн гэж нэрлэсэн нь уламжлалт монголоо нэгтгэх бодлого агуулагдаж байсан гэж үзэж байна. II дайны үед явуулсан Монгол улсын гадаад бодлого нь бүхэлдээ нийтийн дайснаас улс үндсээ аврах хүнд бэрх жилүүд байсан бөгөөд түүнд өөрийгээ аварч гарсан билээ.

Монголын дотоод хэрэгт хэт оролцож монголын эрх ашгийг хохируулж байгааг бүр 1926 онд А.Амар, Н.Жадамба нар зориглон түүнийг нь ЗХУ-ын Гадаад Харилцааны Ардын Комиссират хүлээн авч тодорхой буулт хийлгүүлж чадсан нь улс үндсээ аврах зоригтой шийдмэг үйлс байлаа. А.Амар бол үндэс угсаагаа аврахын төлөө ариун шудрагаар тэмцэж амь насаа өгсөн үндэсний баатар байлаа. "А.Амар шинэ тулгар" тогтсон төр засагт үнэнхүү тулхтай улс төрийн томоохон зүтгэлтэн, бичиг эрдэмд гүнзгий боловсорсон билгүүн номч эрдэмтэн байсныг өөрчлөлт шинэчлэлтийн үрээр бид мэдэрч эхэлж байна"<sup>34</sup> гэсэн дүгнэлтэнд судалгааныхаа дүнд эрдэмтэн Ж.Болдбаатар хүрчээ.

Тусгаар тогтнол үндэс угсаагаа аврах их ариун шударга үйлсэд ямар гай гамшиг, нүсэр хүнд бэрхшээл учирсныг хэлж барахын аргагүй. Түүний гадаад дахь хүчин нь коминтерн ЗХУ байсан бол тэдний тулгалт шахалтаар дотоодод хэрэгжүүлэгчид нь Х.Чойбалсан тэргүүтэй балмад хүчин биелэн босож монгол монголоон үйл олноор нь "хувьсгалын эсэргүү", "Японы тагнуул" гэдэг зохиомол хэргээр хомроглон егүүтгэсэн гашуун хар мөр үлдээжээ. Цөөхөн хэдэн монголоон яаж өсгөж өндийлгөх, үндэсний эв нэгдлийг яаж бэхжүүлэхийн төлөө тэмцэлд аймшигт сөрөг цохилт болсныг харуусан тэмдэглэж байна. Хэлмэгдүүлэлт тухай тухайн үед өөр өнгө зүстэй, нэр хаягтай байсан ч үндэс угсаагаа хөнөөн сөнөөх мөн чанар нь ямагт хэвээр байсан.

Феодалын хөрөнгө хураалт бол оршин тогтнох эдийн засгийн үндсийг нь хүчирхийлэн бусниулан устгаж эздийг нь хувьсгалын эсэргүү хүчин нэрийн дор хяргасан билээ.

Оюуны салбарын нөлөө бүхий шашны лам нарын уламжлалт давхрааг шашин, сүм, хийдийн асуудлыг шийдвэрлэх гэдэг нэрийн дор эрдэмт хутагт, хувилгаад том лам нарыг дайсанд үзэн хөнөөж, сүм хийдийг нураан, бурхан тахилыг нь сүйтгэн, ном судрыг шатааж, сүшиг бишрэлийг доромжлон, хүчээр хар болгосон нь улс үндсээ хөнөөх аюул болжээ. Японы тагнуул нэрээр тэр үеийн нам, төр засгийн зүтгэлтнүүдийг жил дараалан хомроглон яйруулж, түүнд жирийн сэхээтэн, албан хаагчид, энгийн ажилчин, малчид, тэр ч байтугай жирийн сурагчид, эмэгтэйчүүд өртсөнийг үндсээ хөнөөх хилэнцэт муу үйл байлаа гэхээс өөрөөр үзэх аргагүй. Хэлмэгдүүлэлтийг гардан хийгчид ч өөрсдөө Х.Чойбалсангаас бусад нь егүүтгэлд толгой дараалан өртсөн билээ.

Гэвч үнэн ёс, ард түмэн үүнийг гэтлэн давсан юм. А.Амарын мэдүүлэг-баримт нь<sup>35</sup> бодит үнэнийг нээн харуулж Орос Монголын алуурчдын бузар булайг уудлан илрүүлсэн цогт дайчин үг нь чухамдаа яллагчдыг олон түмэнд хүртээх хурц дайчин уриа болсон юм. Алуурчдын үйл ажиллагаа хумигдаж эхэлсэн нь Амарын үйл ажиллагаатай холбоотой гэж үзсэн зарим судлаачдын санал оргүй зүйл бишээ. Иймээс А.Амар хэмээгч ухаант их хүн бол тоталитар дэглэм, төрийн бурангуй хэлмэгдүүлэлтийн эсрэг сөрөн зогссон анхны зоригт тэмцэгч байжээ.

1940-өөд он болж ирэхэд төрийн хямрал, хэлмэгдүүлэлт өөрийн эрхгүй намдаж эхэлсэн юм. Энэ нь улс үндэстний эрх ашиг, амиа авч үлдэн улмаар цэцэглэн хөгжихийн төлөө төр засгаа бэхжүүлэх, ардчилах, ертөнцийн хэн гуайтай ч дөрөө харшин зэрэгцэх агуу их ухаан давамгайлсан билээ.

<sup>34</sup> Ж.Болдбаатар. Амар сайд. Булган хот. 1993. 60 тал

<sup>35</sup> "Үнэн". 1995. №15 /16379/



1940 онд Улсын VIII их хурлаа хуралдуулж, Үндсэн хуулиа шинэчлэн батлав. Энэ бол монгол үндэстний гай гамшигт балчигаас өндийн нүд нь өөдөө, зовхи нь дээшээ харсан үндэстний их баяр болсон юм. Шинэчилсэн Үндсэн хуулинд улс үндсээ "Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан "малчид, ажилчид, сэхээтэн" хөдөлмөрчдийн тусгаар тогтносон бөгөөд, цаашид нийгэм журамд дэвшин орохын тулд тус орныг хөрөнгөтний бус замаар хөгжүүлэгч улс мөн"<sup>36</sup> гэж тодорхойлжээ.

"1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хууль нь социалист шинжтэй, ангич чанартай үндсэн хууль байв"<sup>37</sup> гэж академич С.Нарангэрэл дүгнээд, уг хуулинд тусгасан социалист шинжүүдийг тоочиж гаргасан байна. Энэ үндсэн хуулиар улсынхаа сүлд далбаа, нийслэлийг тогтоон баталсан нь энгийн нэг зүйл байгаагүй ээ.

Дэлхийн гамшигт II дайн дууссаны дараа олон улсын байдал үндсээрээ өөрчлөгдөж хоёр систем бий болсон нөхцөлд монголчуудын өмнө удамт монголоо дэлхий нийтээр зөвшөөрүүлэх өргөн бололцоо нээгдсэнийг соргог ухааран чадварлаг хөдлөхийг түүх бидний өмнө зүй ёсоор дэвшүүлсэн байна. Энэ үед манай төр, намын толгойд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нар нэгэнт дэвшин гарсан байлаа. Чухамхүү энэ үед монголчуудын төрт ёс, үндэс угсаагаа хамгаалан өөдлүүлдэг агуу уламжлалаа дэлхийн цар хүрээнд тавьж хэрэгжүүлэх бололцоо нээгдсэн гэж хэлж болно. Монголын нам төр засгийн зүтгэлтнүүдийг ЗХУ-ын Засгийн газар Сталинд дайны дараа БНМАУ-аа дэлхийн том гүрнүүдээр зөвшөөрүүлэх ухаалаг санал тавьж, түүнд ойлгуулж чадсан юм. И.Сталин Чанкайшийн эсэргүүцлийг чадварлаг няцааж "өнөөдөр гадаад Монгол бол хэрэг дээрээ нэгэн ардын Бүгд найрамдах улс юм. Одоогийн байдал гэгч нь тусгаар тогтнолыг хэлж байгаа юм" гэжээ. Энэ нь Дундад Иргэн Улсад өөрт нь ашигтай болохыг хэлжээ.

И.Сталин, 1945 онд болсон гурван гүрний Крымийн бага хурлаар нийтийн эрх ашигтай нийцүүлэн болзол тавьж, БНМАУ-ын тусгаар тогтносон байдлыг одоогийн хил хязгаараар нь хэвээр тогтоосон нь ЗХУ, Англи, Америк гурван их улс манай тусгаар тогтнолыг хэрэг дээр зөвшөөрөн хүлээсэн хэрэг болов.

Дундад Иргэн Улс Монголын тусгаар тогтнолын асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулж тэр нь баталж чадвал зөвшөөрнө гэснээр санал асуулга явагдаж, хүн амын 98,4 хувь нь оролцож бүгдээр улсынхаа тусгаар тогтнолын төлөө саналаа өгсөн нь манай гадаад бодлогын шинэ ололт байлаа. Гадаадынхан тусгаар тогтнолоо хамгаалж чадаж тодорхой алхмууд хийж байгаад ч гайхаж байсан юм.

1946 онд Хятад улс Монголыг нэгтгэх холын муу санаагаа хаяагүй ч монголын тусгаар тогтнолыг аргагүй хүлээн зөвшөөрч 1946 оны II сард дипломат харилцаа тогтооход хүргэсэн нь тусгаар тогтносон БНМАУ бодитой оршин буйгаа зөвшөөрүүлж чадсан, улс үндсээ хамгаалсан чухал үйл явдал болсон байна. Дараа нь БНХАУ байгуулахад манай улс эн түрүүн дипломат харилцаа тогтоосон нь улс үндсээ авран хамгаалах холч бодлого болсон бөгөөд 1950-иад оны дунд харилцаа хүйтэрч эхэлсэн тогтворгүй болсон үед ч улс үндэстнийхээ эрх ашиг, үндэс угсаагаа авран хамгаалж чадсан юм.

БНМАУ-ыг Хятадынх болгох саналыг ЗХУ-д удаа дараалан тавьж байсан, цэрэг зэвсгийн халдлага, заналхийлэн, ном зохиол олноор нийтлэн үймүүлж, газрын зурагтаа БНМАУ дэвсгэр нутгийг Хятадад оруулан хэвлэж байсан бөгөөд энэ нь 1970 онд Зөвлөлтийн цэргийг манай хүсэлтээр оруулан байрлуулж, улс үндсээ тэдэнтэй хамтран сахихад хүргэж байсныг мартах ёсгүй.

<sup>36</sup> БНМАУ-ын их бага хурлын тогтоол, үндсэн хууль, тунхагууд. УБ. 1956

<sup>37</sup> Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. УБ. 2001. 41 тал

1946 оны II сард Монгол-Зөвлөлтийн найрамдал, харилцан туслалцах гэрээ байгуулагдсан нь үндэсний аюулгүй байдлаа хангаж чадсан юм. Дайны дараах гадаад бодлогот ЗХУ-ыг шүтэх, түших, найдах бодлого голлосон хэвээр байж “ахан дүүс”, “Орос ах нар” гэдэг нэр томъёо гүнээ нэвтэрчээ. БНМАУ-ын социализмын орнуудтай гадаад харилцаа улам өргөжиж, 1960 онд 17 оронтой, 1990 онд 107 оронтой дипломат харилцаа тогтоожээ.

Манай улс бусад орнуудтай тэгш эрхтэй, найрсаг харилцааг үндсэн зарчим болгож хэрэгжүүлж чадсан нь улс үндэснийхээ бие даасан байдлыг бэхжүүлж, монгол монголоороо үлдэж чадсан юм. Энэ үед хүчирхэг өрнөсөн дэлхий дахины энх тайвны хөдөлгөөнд тууштай оролцож ирсэн нь Монголын нэр хүндийг олон улсын дунд өндөржүүлэв. БНМАУ, НҮБ-д саналаа дэвшүүлсэн нь хэдийгээр хүслээр болоогүй ч Монгол улс дэлхийн тавцанд биеэ даасан бодлого явуулж эхэлснийг харуулна. Монголын нэр хүнд өндөржсөнийг бүр 1955 онд НҮБ-ын чуулган дээр олонхи гишүүд БНМАУ-ыг НҮБ-д элсүүлэх саналыг дэмжиж 1957 онд Кайрийн бага хурлаас “БНМАУ-ыг НҮБ-ын гишүүнд даруй элсүүлэх ёстой” гэсэн шаардлага тавьж, 1957 онд БНМАУ-ыг дэмжих өдрийг явуулж бусад улс орнуудад Монголтой найрамдах нийгэмлэгүүд байгуулагдсан зэрэг нь нотлон харуулав. Дэлхийн дэмжлэгийг хүлээсэн Монгол 1961 онд НҮБ-д нүүр бардам элссэн нь түүхэн зайлшгүй зүй тогтлын биелэл байлаа.

Монголчууд өөрийгээ ингэж зөвшөөрүүлж, дэлхийн итгэлийг хүлээж, Монгол тусгаар тогтнож, яс махаа хадгалж үлдэж байх үед монголын дотоодод улсынхаа тусгаар тогтнолыг устгаж, ЗХУ-тай нэгдэх санаатан байсан бөгөөд үүнийгээ ганцхан социализм байгуулахаар шалтаглан улс үндэс уусах аюул, яс цусаа эрлийзэн саармагжих аюулыг огтхон ч бодоогүй байна. Тэд хэн бэ? үүнийг цухас боловч хэлэхгүй өнгөрч болохгүй байна. Нам, төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан Б.Жамбалдорж гэгч бүр 1944 оны VII сард НТХорооны улс төрийн товчоонд ирүүлсэн бичигтээ: “... манай Монгол улс зөвлөлтийн аугаа их гэр бүлд багтах нь ... цаг нь болсон” гээд цаашдын түргэн хөгжилд их л утгатай хэмээн учирлан мэдэмхийрсэн байна.

Ер энэ үеийн зарим сэхээтэн, албаны хүмүүсийн дотор улс орны хөгжлийн явцад тохиолдсон бэрхшээлийг өөрийн хүч бололцоо, нөөцөө дайчлан, зорьсондоо хүрэх, ялах сэтгэл санааны их тэнхээ гаргаж, арга замыг тодорхойлж өгөхийн оронд мэгдэн цөхөрсөн, гутранг үзэл газар авч, ЗХУ-д нэгдэх, дагаар орвол л бүтэх бөгөөд түүнийгээ ямагт социализм байгуулахтай холбон тавьж байлаа.

Үнэндээ энэ бол ард түмнийхээ бүтээлч хүчинд үл итгэсэн, улс үндэснийхээ эрх ашигт тэрсэлсэн хэрэг байлаа. Зарим нь Улс Төрийн Товчоон дээр “нэгдээ” гэж усан нүдэлж явсан мэдээ бий. МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга асан Ч.Сүрэнжав 1944 онд Зөвлөлтийн бүрэн эрхт төлөөлөгч И.Ивановтай уулзаж БНМАУ-ыг ЗХУ-д нэгтгэх асуудлыг тавьж байсан байна. АИХ-ын орлогч дарга Цэдэв энэ асуудлыг тавьж байсан юм<sup>38</sup>.

Үүнээс анхаарал татдаг нэг баримт бол 1950 оны VIII сард Монголыг ЗХУ-ын бүрэлдэхүүнд оруулах замаар социализм байгуулах асуудлыг шийдвэрлэх гэсэн нэр бүхий /С.Авирмэд, Г.Галбадрах, Ц.Дүгэрсүрэн, Б.Бадарч, Д.Төмөр-Очир, Л.Цэнд/ хэдэн сэхээтний нам, засгийн дээд удирдлагад бичсэн захидал юм. Түүнд “Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд багтан ороогүй цагт манай оронд социализм бүрэн ялах явдал өнө удаан хугацаа шаардагдах маш хэцүү юм шиг санагдаж байна” гэж үзээд түүнийгээ 7-8 зүйлээр зайлшгүй болохыг нотлохыг оролдсон байдаг.

Ийм санал боловсруулж тавихыг зарим нь Х.Чойбалсан, нөгөө нэг нь Ю.Цэдэнбал санаачлан зохион байгуулсан гэцгээж байна. Хэргийн гол нь үүнд

<sup>38</sup> Засгийн газрын мэдээ. 1995 №185 /427/



1940 онд Улсын VIII их хурлаа хуралдуулж, Үндсэн хуулиа шинэчлэн батлав. Энэ бол монгол үндэстний гай гамшигт балчигаас өндийн нүд нь өөдөө, зовхи нь дээшээ харсан үндэстний их баяр болсон юм. Шинэчилсэн Үндсэн хуулинд улс үндсээ “Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан “малчид, ажилчид, сэхээтэн” хөдөлмөрчдийн тусгаар тогтносон бөгөөд, цаашид нийгэм журамд дэвшин орохын тулд тус орныг хөрөнгөтний бус замаар хөгжүүлэгч улс мөн”<sup>36</sup> гэж тодорхойлжээ.

“1940 онд батлагдсан БНМАУ-ын үндсэн хууль нь социалист шинжтэй, ангич чанартай үндсэн хууль байв”<sup>37</sup> гэж академич С.Нарангэрэл дүгнээд, уг хуулинд тусгасан социалист шинжүүдийг тоочиж гаргасан байна. Энэ үндсэн хуулиар улсынхаа сүлд далбаа, нийслэлийг тогтоон баталсан нь энгийн нэг зүйл байгаагүй ээ.

Дэлхийн гамшигт II дайн дууссаны дараа олон улсын байдал үндсээрээ өөрчлөгдөж хоёр систем бий болсон нөхцөлд монголчуудын өмнө удамт монголоо дэлхий нийтээр зөвшөөрүүлэх өргөн бололцоо нээгдсэнийг соргог ухааран чадварлаг хөдлөхийг түүх бидний өмнө зүй ёсоор дэвшүүлсэн байна. Энэ үед манай төр, намын толгойд Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал нар нэгэнт дэвшин гарсан байлаа. Чухамхүү энэ үед монголчуудын төрт ёс, үндэс угсаагаа хамгаалан өөдлүүлдэг агуу уламжлалаа дэлхийн цар хүрээнд тавьж хэрэгжүүлэх бололцоо нээгдсэн гэж хэлж болно. Монголын нам төр засгийн зүтгэлтнүүдийг ЗХУ-ын Засгийн газар Сталинд дайны дараа БНМАУ-аа дэлхийн том гүрнүүдээр зөвшөөрүүлэх ухаалаг санал тавьж, түүнд ойлгуулж чадсан юм. И.Сталин Чанкайшийн эсэргүүцлийг чадварлаг няцааж “өнөөдөр гадаад Монгол бол хэрэг дээрээ нэгэн ардын Бүгд найрамдах улс юм. Одоогийн байдал гэгч нь тусгаар тогтнолыг хэлж байгаа юм” гэжээ. Энэ нь Дундад Иргэн Улсад өөрт нь ашигтай болохыг хэлжээ.

И.Сталин, 1945 онд болсон гурван гүрний Крымийн бага хурлаар нийтийн эрх ашигтай нийцүүлэн болзол тавьж, БНМАУ-ын тусгаар тогтносон байдлыг одоогийн хил хязгаараар нь хэвээр тогтоосон нь ЗХУ, Англи, Америк гурван их улс манай тусгаар тогтнолыг хэрэг дээр зөвшөөрөн хүлээсэн хэрэг болов.

Дундад Иргэн Улс Монголын тусгаар тогтнолын асуудлаар бүх нийтийн санал асуулга явуулж тэр нь баталж чадвал зөвшөөрнө гэснээр санал асуулга явагдаж, хүн амын 98,4 хувь нь оролцож бүгдээр улсынхаа тусгаар тогтнолын төлөө саналаа өгсөн нь манай гадаад бодлогын шинэ ололт байлаа. Гадаадынхан тусгаар тогтнолоо хамгаалж чадаж тодорхой алхмууд хийж байгаад ч гайхаж байсан юм.

1946 онд Хятад улс Монголыг нэгтгэх холын муу санаагаа хаяагүй ч монголын тусгаар тогтнолыг аргагүй хүлээн зөвшөөрч 1946 оны II сард дипломат харилцаа тогтооход хүргэсэн нь тусгаар тогтносон БНМАУ бодитой оршин буйгаа зөвшөөрүүлж чадсан, улс үндсээ хамгаалсан чухал үйл явдал болсон байна. Дараа нь БНХАУ байгуулахад манай улс эн түрүүн дипломат харилцаа тогтоосон нь улс үндсээ авран хамгаалах холч бодлого болсон бөгөөд 1950-иад оны дунд харилцаа хүйтэрч эхэлсэн тогтворгүй болсон үед ч улс үндэстнийхээ эрх ашиг, үндэс угсаагаа авран хамгаалж чадсан юм.

БНМАУ-ыг Хятадынх болгох саналыг ЗХУ-д удаа дараалан тавьж байсан, цэрэг зэвсгийн халдлага, заналхийлэн, ном зохиол олноор нийтлэн үймүүлж, газрын зурагтаа БНМАУ дэвсгэр нутгийг Хятадад оруулан хэвлэж байсан бөгөөд энэ нь 1970 онд Зөвлөлтийн цэргийг манай хүсэлтээр оруулан байрлуулж, улс үндсээ тэдэнтэй хамтран сахихад хүргэж байсныг мартаж өсгүй.

<sup>36</sup> БНМАУ-ын их бага хурлын тогтоол, үндсэн хууль, тунхагууд. УБ. 1956

<sup>37</sup> Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал, шинэчлэлийн зарим асуудал. УБ. 2001. 41 тал

Тойрон хүрээлэгчдийн хэлсэн үг, бичсэн юманд улс үндэснийхээ хувь заяа, яс угсааныхаа төлөө гэмээр олигтой ганц ч юм байхгүй гэж хэлж болно.

Тэд бол үндэснийхээ эрх ашгаа огоорсон, нэр алдар албан тушаалын хэнээтнүүд байсан гэж бүрэн утгаар хэлж болно. Тэд түүхээ, соёлоо, хэлээ, ёс заншил, уламжлалаа мэддэггүй "дарганцарууд" байлаа. Тэдний дунд Д.Бодоо, С.Данзан, Б.Цэрэндорж, А.Амар, Г.Бумцэнд нар шиг төрийн нуруутай төрмөл монгол ухаантай улс төрч даанч байсангүй. Энэ үед Ю.Цэдэнбал улс төрийн бодлогын хүрээнд ганцаардаж, эрх мэдэлгүй бусдын амаар явах болсон гэж хэлж болно. "Ю.Цэдэнбал ЗХУ-ын ... нөхөрсөг зөвлөгөө, захиран сургамжилсан зааврыг сонсож, дарамт шахалтад нэг бус удаа орж явсан төдийгүй түүнийг хүлээн авч, хэрэгжүүлэхээс өөр аргагүй байсан ажээ"<sup>40</sup> гэсэн судлаачийн дүгнэлтийг үндэстэйд үзэх нь зөв. Судлаач Б.Лхамсүрэн, Ш.Г.Надиоров, Ж.Болдбаатар, Ц.Гүрбадам, Н.Жамбалсүрэн, Ч.Мижээхүү, С.Отгонжаргал нар үнэнд ойртсон, санаа дүгнэлт нэлээдгүй гаргасан гэж би хувьдаа үздэг юм. Энэ бол Монгол үндэстний хойшид оршин тогтнох хувь заяаны асуудалтай шууд холбогдож байгаа юм.

1950-иад оны сүүлчээс феодализмаас социализмд шилжих шилжилт дууслаа. Социализмын үндсийг байгуулж, социализмыг байгуулж дуусгах шатандаа орлоо гэсэн үндэс муутай дүгнэлт, зорилт газар авсан байна. МАХН, энэ үед зорилгоо үзэл суртлаар хангаж хүн ардаа марксизм-ленинизмээр цэнэглэж, шашингүйчүүдийн орон болгож, коммунист хүмүүжлээр хүмүүжүүлэх, уламжлалт үндэсний үзлийн эсрэг пролетарийн интернационализм, социалист интернационализм Зөвлөлт-Монголын найрамдалд үнэнч байх үзлийг сөргүүлэн тавьжээ. Улс үндсээ гэсэн, соёлын өв, түүх, хэл, монгол ёс суртхуун, зан заншлаа гэсэн эрдэмтдийг буруутгаж үндсэрхэх үзэлтэн хэмээн нэр хаяг зүүж, хяхан хавчин болов. Академич Б.Ринчен, Ц.Дамдинсүрэн, нэрт эрдэмтэн Х.Пэрлээ, Ш.Гаадамбал, намын ажилтан З.Содномцэрэн зэрэг улс үндэснийхээ эрх ашгийн төлөө үзэл бодолтон эн түрүүнд өртөгдлөө. 1960-1980-аад онд энэ бурангуй үйлдэл гүнзгийрч, олон эрдэмтэн сэхээтэн жирийн хүмүүс ч хамрагджээ. Энд яригдаж байгаа үед ч, 1990-ээд оноос хойшхи үйл явцад ч хамааруулан их эрдэмтэн Ш.Гаадамбын ард түмэндээ хандаж, монгол хүн, монгол үндсээ гэж захисан захиас үнэнийг гайхмаар барьж, сургаалын чанартай болсон юм.

Тэрээр " ... хэрэв та монголын эх оронч иргэн мөн л юм бол хүн нэг бүрийн амь үндэстэнд бий. Улс үндэстний амь, түүний төлөө ард иргэн нийтийн амь хайргүй тэмцэлд бий гэдгийг ухаарч, амин хувиа хичээх, мэдэхгүй юмандаа мэдэмхийрэх, чадахгүй юмандаа сачийгаа мэдэхгүй санаархах энэ гурваас л тахал шиг зугатааж яваач гэж амин зүрхнээсээ гуймаар байна"<sup>41</sup> гэж яруу тодорхой, хурц дайчин өгүүлжээ. Гэтэл үзэл суртлаар дарамталж хүмүүсийн оюун санааны олон ургальч үзлийг хааж боох нь бүр 1960-аад онуудад гүнзгийрэн явагдаж иржээ. Улс үндэснийхээ эрх ашгийг хохироосон боддлого явуулсан тэр үеийн нам, төр засгийн зүтгэлтнүүд Давст уулынхаа талыг алдаж, Дархадын нутгийн хойт захын хил нь Бэлмийн голын гольдрол, түүний эхний шар даваа хүртэл байсныг алджээ<sup>42</sup>. Үүнийг газар нутгийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдлаа эрхэмлэдэг хүмүүс гэж тэднийг үзэж болох уу. Үндэсний эрх ашгаа хөсөрдүүлсэн гутамшиг гэхээс өөрөөр нэрлэх аргагүй.

Бас нэг адил түүхт явдал "Соёлын довтолгоо"-г зохион байгуулж шуурхайлан довтолсон арга хэмжээ юм. Үүнд нааштай зүйл байх авч нугалах завхруулах шинжтэй, ард үндэсний хэв заншил, ёс суртахуун шашин шүтлэгт харшилсан монголоо гэхээсээ найрамдал тэргүүнд тавигдаж, цаашдаа соёлын аян болж үргэлжилсэн билээ. Энэ бол Монголын нам, төр засгийн удирдагчдын

<sup>40</sup> Үнэн. Засгийн газрын мэдээ. 1995 № 185 /427/

<sup>41</sup> "Үнэн" 1993 № 63 /18231/

<sup>42</sup> "Үнэн" 1993. №41



"зүүний" цочмог ойворгон элдэв хувьсгал, довтолгоон, аян, өөрчлөлт шинэчлэлт гэж хөөрдөг хоосон мөрөөдөл хийрхэл байжээ. Үндэсний үзлийн эсрэг хийсэн бас нэг дуулиант хэрэг бол "Намын эсрэг бүлэг" гэгчийг "илрүүлэн бутцохисон" явдал юм.

МАХН-ын Төв Хорооны бүгд хурлууд дээр Ц.Лоохууз, Б.Нямбуу, Б.Сурмаажав нар удаа дараалан ажил төрлийн алдаа дутагдал урагшгүй үхээнц байдлыг хурц шүүмжлэн үүний бурууг МАХН-ын төв хороо, улс төрийн товчоо, Ю.Цэдэнбал хүлээх ёстой гэж шударгаар тавьжээ. 1964 оны III сард хуралдсан Төв Хорооны бүгд хурал тэдний тавьсан шүүмжлэл эрүүл саруул саналыг хүлээж авахын оронд зүйл бүрээр мушгин "няцаалт" өгч, намын биш захиргаадан тушаасан тогтоол гаргаж, шударга үнэнч эдгээр гишүүдээ Намын Төв Хорооны гишүүнээс үндэсгүй хасаж, ажил төрлөөс нь халж, газар заан цөлж, хувийн амьдралыг нь үзэшгүй хохироож, заримыг нь шоронд хорьсон бөгөөд тэднийг 1990-ээд он хүртэл итгэл үл хүлээлгэн мөшгөсөөр байжээ.

Ц.Лоохууз, Б.Нямбуу нар "улс орон зээлийн хөрөнгөөр амьдарч байна" гээд дэлхийн зах зээл дээр өндөр эрэлт хэрэгцээтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тийм үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэх тухай онцлон ярьсан нь улс үндэснийхээ эдийн засгийн биеэ даасан бүтцийг тогтоох замаар хөгжүүлэх нь монголчууд улс үндсээ авран хамгаалж, аван явах зөв зам гэж үзэж, үндэсний үзэл санаа бүхий бодлоо хэлжээ.

Бас Ц.Лоохууз эх орон, социализмын төлөө санаа зовсон сэхээтнүүдийг монгол, зөвлөлтийн найрамдлын эсрэг хандаж байна гэж зэмлэгчдийг шүүмжилсэн байна<sup>43</sup>.

"Намын эсрэг бүлгийнхэн" гэгчдийн ярьсан хэлсэн зүйлд ер эсрэг гэх зүйлгүй бөгөөд захиргаадалт, хүнд суртал, тахин шүтэх явдал байгааг л тухайн үед нь илрүүлэн тавьсан байдаг. Улс төрийн уур амьсгал өөрчлөгдөж эхлээд байсан үед НТХ-ны V бүгд хурал /1986/ хуралдаж тэр үеийн нам төрийн тэргүүн Ж.Батмөнх, "... Х.Чойбалсанг тахин шүтэж байх үед ч, түүнээс хойших бүх үеийн дотор ч сэхээтэнд эмзэглэж хандах эрүүл биш байдал намын удирдлагын зүгээс нэг биш удаа гарч байсан нь нууц биш юм. ... харилцан ойлголцохын оронд "сэхээтний төөрөгдөл" гэгч нэр хаяг зүүж, дээрээс цаатгайд нь буруушаан няцаалт өгсөн нь шинээр өсөн бойжиж байсан сэхээтний урмыг хугалсан ноцтой гажуудал байлаа" гэсэн нь хожуу боловч МАХН сэхээтнийхээ өмнө буруугаа хүлээсэн зөв дүгнэлт байлаа.

1970-аад онууд, 1980-аад оны эхээр үндсэрхэх харш үзэлтэн гэгдэгчдийг мөрдөж мөшгөж бүтээлийн нь хорих, шатаах, урж тастах, мөнгөн торгууль ногдуулж, сүр дуулиантай олон тогтоол гаргаж дарж байлаа. "XX зууны II хагасаас эх оронч болон Нармай Монголын үзэл санаатай хүмүүсийг үндсэрхэх үзэлтэн нэрээр нухчин дарах, хяхах хавчих бодлогыг МАХН, төр, засгаас өрнүүлэх болсон юм"<sup>44</sup> гэсэн судлаачдын дүгнэлт үнэн юм.

1990 оноос хойш улс үндсээ гэсэн үзэл санаа чөлөөтэй болж, судлаачдын бүтээлүүд гарч, бас үндэсний ёс заншлаа сэргээх ажил явагдаж байгаа ч хий мэдэмхийрэх, будаж шунхдах ор тас үгүйсгэх, улс төржүүлэн гуйвуулах явдал олноор гарч "тус болохоосоо ус болох" гээч болж байна. Эрдэмтэн С.Отгонжаргал "Аливаа нам наманцар бүр л хөтөлбөрөлхүү зүйл дэвшүүлсэн боловч бүгд утга төстэй, түүнээ зөвшөөрцгөөдөг хэрнээ зарим нам биелүүлэх арга маань өөр гэхээс цаашгүй.

... Нам, наманцрауд олон нийтийг тал тал тийш нь талцуулан хувааж хэрэг дээрээ хагалан бутаргаж байна"<sup>45</sup> гэсэн дүгнэлт хийсэн нь үнэний хувьтай юм.

<sup>43</sup> Үнэн. 1990. № 47

<sup>44</sup> МУИС-ийн "Түүх" ЭШБ. 188. /14/ 2002. 16-р тал

<sup>45</sup> Л.Бат-Очир, С.Отгонжаргал. XX зууны Монгол дахь улс төрийн түүхэн зйл явц. УБ. 1996. 102 тал

XXI зууныг алхаж ороод байхад улс үндсээ даяаршил гэгч аймшигт уусгах хүчний аюулаас хэрхэн аврах, монгол үндэстэн аж терж, оршин тогтнох чиг баримжаа олигтой цэгцэрсэн үзэл бодлын хөтөлбөр гэмээр юм тогтоогүй байна. Улс үндэстнээ уусгаж алдахгүйн тулд ухаалаг бодлого, үйл ажиллагаа, монголоо гэсэн чин үнэн ч төр засаг, эв зөийн бат холбоо, үндэсний онцлогоо өнөө үетэй зөв хослох монгол эх оронч хүн бүрийн хүчин зүтгэл амин чухал байна. *Монголыг Монголчууд аварна.*

**Abstract:**

The survival of the Mongolian nation, sandwiched between the two gigantic powers, having fallen under the influence of both for centuries, and having played a buffer role in their relations, is a reflection of the small states' bandwagoning policy toward the big players.

Throughout the so-called Manchu oppression, the Mongols have preserved the core elements of their rich culture, such as language, history, traditions, territorial affinity, folk art and musical performances and national identity. In the 20<sup>th</sup> century, carrying its unique cultural heritage, and preserving the nomadic lifestyle through foreign domination was a result of "appeasing" the Soviets, taking the advantage of the latter's lack of motivation to absorb Mongolia. The outcomes of such "appeasement" policy were the institutionalization of a sovereign state, first in the form of a constitutional monarchy in 1921, then in the form of a republic since 1924, and finally, as a full-fledged member of the United Nations since 1961.